

Төрийн албаны зөвлөлийн
2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн
131 дүгээр тогтоолын 12 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Албан тушаалын нэр:

Нийгмийн даатгалын бодлого,
төлөвлөлт, нийгмийн хамгааллын
хэлэлцээр хариуцсан ахлах шинжээч

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Бодлого, төлөвлөлтийн газар

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын байрны албан ёсны байршил:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-5,
Улаанбаатар-15160

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, төлөвлөх, хамтран ажиллах хэлэлцээрийн санал боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Нийгмийн даатгалын бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжийн төсөл боловсруулах.
2. Хууль, тогтоомжийн төсөл, бодлогын шинэчлэлийн хүрээнд тооцоо судалгаа хийх, нийгмийн даатгалын бодлогын төлөвлөлт хийх.
3. Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн төсөл боловсруулах.
4. Нийгмийн даатгалын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах.
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нийгмийн даатгалын тухай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах;	Боловсруулсан баримт бичиг нь хууль тогтоомжид нийцсэн, үндэслэлтэй байна.	Г
	2.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд нийгмийн даатгалын холбогдох хуулийн болон бусад дагалдах хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл шинэчлэн боловсруулах;	Төсөл нь хууль тогтоомжид нийцсэн, хэл зүй, найруулгын алдаагүй байна.	Г
	3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийгмийн даатгалын чиглэлээр тусгах зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээний хувилбарын төсөл боловсруулах;	Хувилбарын санал нь үндэслэлтэй, хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хууль, тогтоомжийн төсөл, бодлогын шинэчлэлийн хүрээнд тооцоо судалгаа хийх, нийгмийн даатгалын бодлогын төлөвлөлт хийх;	Хууль, тогтоомжийн төслийн тооцоолол, үр нөлөө, зардлын тооцоо үндэслэлтэй хийгдсэн байна.	Г
	2.Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, чиглэл, заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой	Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагыг тооцож, төлөвлөсөн байна.	Г



	орлого, зарлагыг тооцож нийгмийн даатгалын сангийн төлөвлөлтөд тусгах.		
3 дугаар зорилтын хүрээнд	1.Гадаад улсад олноор оршин суугаа Монгол Улсын иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор гадаад улс, орнуудтай байгуулах нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төсөл боловсруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулах;	Хууль тогтоомжид үндэслэн Монгол Улсын иргэд оршин суугаа улстай байгуулах нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг тэгш, харилцан ашигтай байх зарчимд нийцүүлэн боловсруулсан байна.	Г
	2.Гадаад улс, орны нийгмийн даатгалын тогтолцооны тухай мэдээлэл, туршлагыг өөрийн орны байдалтай харьцуулан судлах.	Өнөөгийн байдлыг судалж, шинэчлэх чиглэлээр олон улсын тэргүүн туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн судалсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нийгмийн даатгалын чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг нэгтгэн зохицуулах, салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх;	Олон улсын байгууллага, донор байгууллагуудын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалтыг хангаж ажилласан байна.	Г
	2.Нийгмийн даатгалын салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн газартай үр дүнтэй хамтран ажилласан байна.	Г
	3.Олон улсын байгууллага, донор байгууллагуудаас нийгмийн хамгааллын хөтөлбөр арга хэмжээг сайжруулах, тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг авах.	Олон улсын байгууллага, донор байгууллагуудаас нийгмийн хамгааллын хөтөлбөр арга хэмжээг сайжруулах, тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр үр дүнтэй хамтран ажилласан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэлэлцэж буй асуудлаар дүгнэлт, санал боловсруулах;	Мэргэжил, арга зүйн туслалцаа нь хууль зүйн үндэслэлтэй байна.	Г
	2.Харьяа байгууллагууд болон бусад холбогдох байгууллагуудад хариуцсан ажлын чиглэлээр мэргэжил	Мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөө нь хууль зүйн үндэслэлтэй байна.	Г



	арга зүйн туслалцаа үзүүлэх;		
	3.Хариуцсан асуудлын хүрээнд хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтоолын төсөл болон эрх бүхий этгээдээс ирүүлсэн асуулга, шаардлага, албан бичгийг судалж хариу өгөх, санал боловсруулах;	Албан бичиг, шаардлагад хууль зүйн үндэслэлтэй, хариу төлөвлөж, хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	4.Хариуцсан асуудлын хүрээнд бусад салбар болон яамны удирдлага, газар, хэлтсүүдтэй хамтран ажиллах, олон нийтэд мэдээлэл өгөх, гарын авлага, зөвлөмж боловсруулах;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г
	5.Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, саналыг судалж холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж хариуг хүргүүлэх.	Албан бичиг, өргөдөл гомдолд хуулийн дагуу хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Санхүү даатгал /0412/; - Эдийн засаг /0311/; - Эрх зүй /042/; - Менежмент ба удирдахуй /041301-041303/. 	
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 8 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын бодлогын талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; - Нийгмийн даатгалын бодлого дахь нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - Нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг зөвлөх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх;



Ур чадвар		<ul style="list-style-type: none"> - Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах; - Асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад.
Багаар ажиллах		<ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - Ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах; - Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах; - бусад.
Бусад		<ul style="list-style-type: none"> - Албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах - Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах; - кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1. Яамны газар, хэлтсийн холбогдох албан тушаалтан;
2. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн ажилтан;
3. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 21 04 14

Дугаар: 131

Ч.ЦЭВЭГДОРЖ

2021 оны 05 дугаар сарын 06 -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2021.05.06.

Дугаар: 0153.

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ӨНӨРБАЯР

2021 оны 05 дугаар сарын 06 -ны өдөр

